Монголбанкны ерөнхийлөгчийн
2006 оны 07 сарын 18-ны өдрийн
34 тоот тушаалын хавсралт

# АРХИВЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОЛОН ВАЛЮТЫН ХАНШИЙН ЛАВЛАГААНЫ ХӨЛС ХУРААХ ЖУРАМ

1.Монголбанкнаас гадны аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд архивын баримтын болон валютын ханшийн талаар лавлагаа өгөхөд Үндэсний архивын газрын даргын 2000 оны 05 дугаар тушаалаар баталсан "Төрийн архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тариф"-ыг жишиг болгон үйлчилгээний хөлс авч байна.

2.Үндэсний архивын газраас тогтоосон тариф тус бүрд Монголбанкны доорх баримт хамаарна. Үүнд:

а)нэг удаагийн тушаал, дүрэм, заавар, журам зэрэг эрх зүйн акт-1500₮
б)цалингийн тодорхойлолт (1 жил) -500₮
в)архивын бусад лавлагаа -1000₮
г)валютын ханшийн лавлагаа -300₮

3.Үйлчилгээний хөлсийг (маягт 1-ийн дагуу) Монголбанкны архивын эрхлэгч 2 хувь үйлдэж бэлэн мөнгөөр хураан авч, нэг хувийг үйлчлүүлэгчид, хоёр дахь хувийг тухайн сардаа багтаан санхүүтэй тооцоо хийнэ.

4.Хууль сахиулах байгууллагууд үүнд хамаарахгүй.

___________oOo___________